



"МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс
санхүүжүүлэх зардлын гүйцэтгэл" нийцлийн аудит

ҮАГ-НАГ/2017/04-НА-ХөААГ

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны
2017 оны 02 дугаар тогтоол,
Хөвсгөл аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга, тэргүүлэх
аудиторын баталсан төлөвлөгөө,
хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн
нийцлийн аудитын тайлан

**Хөвсгөл аймгийн
Сонгуулийн хороо
сонгуулийн зардлыг
хууль, журмын дагуу
зарцуулсан байна.**

**Хөвсгөл аймаг
2017 оны 8 дугаар сар**





**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2017 оны 8 сарын 4 өдөр

Дугаар А/17

Мөрөн

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121, 2017 оны А/12 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл" нийцлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, Хөвсгөл аймгийн сонгуулийн хороонд тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн сонгуулийн хорооны дарга Х.Ган-Очир-т зөвлөсүгэй.
4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Г.Эрдэнэчимэг/, ахлах аудитор /Б.Тэгшдэлгэр/ нарт даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ОЮУНГЭРЭЛ

АГУУЛГА		№
Тайланг бэлтгэсэн: Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын газар Тайланг бэлтгэсэн: ХөААГ-ын Нийцлийн аудитын баг Тэргүүлэх аудитор Г.Оюунгэрэл Утас: 99909224 Аудитын менежер Г.Эрдэнэчимэг Утас: 99016320 Ахлах аудитор Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Ахлах аудитор Л.Энх-амгалан Утас: 96383478 2017 оны 8 дугаар сар Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү. www.audit.mn Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043 дугаарын утас, 70383793 дугаарын факсаар харилцана уу? ХАЯГ: (Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын А байр 3 давхарт)	Товчилсон үгийн жагсаалт	3
	Аудит хийх үндэслэл, зорилт, хамрах хүрээ, арга зүй	4
	Аудитад ашигласан хууль, тогтоомж, шалгуур үзүүлэлт	5
	Үндсэн мэдээлэл	5
		6
	БҮЛЭГ 1. МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилаж, зарцуулсан байна.	6
	1.1 Хөвсгөл аймагт Сонгуулийн Ерөнхий Хорооноос Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардалд 666,0 сая төгрөгийг хуваарилсан байна.	8
	1.2 Төсвөөс олгосон хөрөнгийг аймгийн сонгуулийн хороо сумдын сонгуулийн хороодод зардлын зүйл тус бүрээр төлөвлөж, хуваарилсан байна.	9
	1.3 Улсын бүртгэлийн хэлтэс батлагдсан төсвийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна.	
	БҮЛЭГ 2. Сонгуулийн зардлын нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй байна.	
	2.1 Сонгуулийн зардлын нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй байна.	
	2.2 Аймгийн Сонгуулийн хороо сонгуулийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.	
3. ДҮГНЭЛТ		
4. ЗӨВЛӨМЖ		

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үг	Тайлбар
МУ	Монгол Улс
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
ОӨУБЕГ	Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар
ХөААГ	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтаар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтыг шалгаж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан аймгийн сонгуулийн хороо болон холбогдох албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг Хөвсгөл аймагт холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилж, зарцуулсан эсэх.
- Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьсан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороо, сумын сонгуулийн тойргийн хороод, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газрыг хамруулан шалгав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, АДБОУС 100, 400, 4100, Нийцлийн аудитын түр журам, удирдамжийг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан тайлан бичиж холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлж байна.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 23 дугаар зүйлийн 23.2, 31 дүгээр зүйлийн 31.7, 31.8, 31.9, 31.10, 31.11, 31.15, 32 дугаар зүйлийн 32.1.1,

- 32.1.3, 32.1.6, 33 дугаар зүйлийн 33.13, 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.6, 36 дугаар зүйлийн 36.7, 38 дугаар зүйлийн 38.2 заалт
- СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “ Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих тайлан гарах журам”
 - СЕХ-ноос батлан гаргасан бусад дүрэм, журам, заавар
 - Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

Бүлэг 1: МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилаж, зарцуулсан байна.

Үндсэн мэдээлэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль зохион байгуулах Хөвсгөл аймгийн сонгуулийн хороог Сонгуулийн Ерөнхий Хорооны 2017.04.12-ны өдрийн 10 дугаар тогтоолоор 9 төрийн албан хаагч, Хөвсгөл аймгийн Сонгуулийн хорооны 2017.04.21-ны өдрийн 01 дугаар тогтоолоор 23 сумын сонгуулийн хороог 161 төрийн албан хаагчийн бүрэлдэхүүнтэй тус тус томилсон байна.

Сумдын сонгуулийн хороод МУ-ын Сонгуулийн тухай хуульд заасан хугацаанд 122 санал авах байранд 786 төрийн албан хаагч ажилласан байна.

Мэдээлэл технологийн багт 150, Иргэний бүртгэлийн байгууллагын 130, Цагдаагийн байгууллагын 122 нийт 402 төрийн албан хаагч ажилласан.

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн шадар туслах 387, ухуулагч 1003, ажиглагч нийт 1004 хүнийг бүртгэж түр үнэмлэх олгосны зэрэгцээ, сонгуулийн сурталчилгаанд ашиглах 501 тээврийн хэрэгслийг бүртгэн гэрчилгээ олгосон байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооны 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 113 дугаар албан бичгийн 3 дугаар хавсралтаар аймгийн сонгуулийн хороо болон сумдын сонгуулийн хорооны дансыг аймаг, сумдын Төрийн санд нээсэн байна.

Иргэний шилжилт хөдөлгөөн, цагдаагийн хамгаалалттай холбоотой сонгуулийн зардлыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан санхүүжүүлсэн байна. Үүнд:

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газраас нийт 104,2 сая төгрөг, Цагдаагийн Ерөнхий газраас нийт 17,4 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

1.1 Сонгуулийн Ерөнхий Хорооноос Хөвсгөл аймагт 666,0 сая төгрөгийн сонгууль зохион байгуулах зардлыг хуваарилсан байна.

Хөвсгөл аймгийн сонгуулийн хорооны 100170022001 тоот дансны 1 дүгээр гарын үсгийг сонгуулийн хорооны дарга Х.Ган-Очир, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Г.Батчулуун нар зурж санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан байна. Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв, хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 2.1, 2.2 дахь заалтын дагуу МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардалтай холбоотой улсын төсвөөс олгох санхүүжилтийн хуваарийг дараах байдлаар Сонгуулийн Ерөнхий Хорооноос баталсан байна. Үүнд:

№	Байгууллага	Тушаал шийвэр	Мөнгөн дүн /мян төг/
4	Сонгуулийн ерөнхий хороо	2017.06.21-210	488830,2
6	Сонгуулийн ерөнхий хороо	2017.07.19-295	177182,0
7	Нийт		666012,2

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн зардал Хөвсгөл аймагт 488,8 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт, хоёр дахь санал хураалтын зардалд 177.2

сая төгрөг тус тус хуваарилсан байна.

Санхүүжилтийн хуваарийг дээрх “Журам”-ын 2.2 дахь заалтын дагуу зардлын нэр төрлөөр төлөвлөж, баталсан байна.

Хөвсгөл аймгийн сонгуулийн хорооны 2017 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 57 дугаар тушаалаар сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардлыг хуваарилсан байна. Үүнд:

- ✓ Сонгуулийн байгууллагын ажилтны хоолны зардал 1 хүнд 50000 төгрөг
- ✓ Мэдээлэл, технологийн багийн гишүүн, санал авах байрны даамалд 30000 төгрөгийг тооцож олгох

Хөвсгөл аймгийн сонгуулийн хорооны 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 37 дугаар тушаалаар:

- ✓ Бичиг хэргийн зардал: Санал авах байр тус бүрт-144000 төгрөг
- ✓ Шуудан холбооны зардал: Санал авах байр тус бүрт-144000 төгрөг
- ✓ Унааны зардал: Нэг санал авах байрны унааны зардлыг 240000 төгрөг
- ✓ Суртчилгааны материал хүргэх зардал: 1 суманд 125000 төгрөг
- ✓ Санал авах байр бэлтгэх зардал: 140000 төгрөг тус тус жигд хуваарилсан байна.

1.2 Төсвөөс олгосон хөрөнгийг аймгийн сонгуулийн хороо сумдын сонгуулийн хороодод зардлын зүйл тус бүрээр төсөвлөж, хуваарилсан байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооноос хуваарилан ирүүлсэн санхүүжилтийг аймгийн сонгуулийн хороо нь “Журам”-ын 2.3 дахь заалт, Сонгуулийн Ерөнхий Хорооноос ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн 23 сумын сонгуулийн хороо, аймгийн сонгуулийн хороодод санхүүжилтийг хуваарилсан байна. Төсөв хуваарилах тус бүрт тайлбар хүргүүлж ажилласан байна.

Үүнд:

№	Сумдын нэр	Ээлжит сонгуулийн төсөв	Дахин сонгуулийн төсөв
1	Алаг-эрдэнэ	20412,6	2819,0
2	Арбулаг	20391,0	2697,0
3	Баянзүрх	17465,4	2260,0
4	Бүрэнтогтох	17487,0	2457,0
5	Галт	17465,4	2260,0
6	Жаргалант	15045,4	2060,0
7	Их-Уул	17465,4	2260,0
8	Рашаант	17415,4	2090,0
9	Ренчинлхүмбэ	17465,4	2185,0
10	Тариалан	17971,0	2497,0
11	Тосонцэнгэл	17415,4	2240,0
12	Төмөрбулаг	13087,8	1703,0
13	Түнэл	20391,0	2697,0

14	Улаан-Уул	15045,4	2060,0
15	Ханх	8668,6	949,0
16	Цагаан-уул	17465,4	2260,0
17	Цагаан-үүр	14309,4	1803,0
18	Цэцэрлэг	21941,4	2939,0
19	Цагаан-Нуур	5202,2	622,0
20	Чандмань-Өндөр	17465,4	2260,0
21	Шинэ-Идэр	13999,0	1783,0
22	Мөрөн	44356,6	4883,0
23	Эрдэнэбулган	17465,4	2310,0
24	Аймгийн Сонгуулийн хороо	83433,2	125088,0
25	Нийт	488830,2	177182,0

Санхүүжилтийг хуваарилахдаа сумдын нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон санал авах байр тэдгээрт ажиллах хүний тоог харгалзан зардлын ангилал тус бүрээр хуваарилсан байна. Сумдын сонгуулийн зардлын данс хаагдсанаас хойш хоёр дахь санал хураалтын сонгуулийн зардал ирсэн тул аймгийн сонгуулийн хорооны зардлын данснаас хоёр дахь санал хураалтад ажилласан сумдын сонгуулийн ажилтан 1106 хүний урамшуулал 110,6 сая төгрөгийг олгосон байна.

1.3 Улсын бүртгэлийн хэлтэс батлагдсан төсвийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Аймгийн сонгуулийн хороо нийт 5 удаагийн санхүүжилтээр 666012,2 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Аймгийн сонгуулийн хорооноос санхүүжилт ирсэн тухай бүрт сумдад хуваарийн дагуу олгож, Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн арга зүйгээр хангаж ажилласан байна.

Сонгууль зохион байгуулах явцад аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч болон бусад холбогдох ажилтнууд сумдын сонгуулийн хорооны ажилтнуудад зардлыг батлагдсан зардлын ангилал тус бүрээр нь зарцуулах талаар удаа дараа зөвлөмж боловсруулан хүргүүлсэн ба утсаар өдөр тутам зөвлөн тусалж ажилласан байна.

Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч сумдын сонгуулийн хорооны зардлын тайланг Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 04 тоот тогтоолоор батлагдсан “Журам”-ын 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу зардлын тайлан гаргуулан авч нэгдсэн тайлан гаргасан байна. “

Нэгдсэн тайлангийн зардлыг зүйл тус бүрээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

№	Зардлын зүйл	Ээлжит сонгууль		Дахин сонгууль	
		Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл
1	Сонгуулийн бичиг баримт болон техник хэрэгслийг сум дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах, тээвэрлэх зардал	23559,0	21774,32	20013,0	14734,4
2	Тогтоол, протокол, албан бичгийн хэвлэмэл хуудас, маягт хэвлүүлэх зардал	250,0	215,6	0	0
3	Сонгуулийн автомажуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	5124,0	5124,0	5124,0	5124,0
4	Дүн мэдээ дамжуулах зардал	7050,0	3416,4	7050,0	6725,0
5	Санал авах байр бэлтгэх тохижуулах зардал	23970,0	23970,0	0	0

6	Сургалтын зардал	24306,0	24265,5	0	0
7	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	282157,2	282126,8	132680,0	132680,0
8	Бичиг хэргийн зардал	27560,0	27560,0	2390,0	2390,0
9	Шуудан холбооны зардал	24610,0	24608,5	3000,0	3000,0
10	Унааны зардал	49805,0	49630,0	6925,0	6775,0
11	Албан томилолтын зардал	6420,0	6420,0		
12	Үнэмлэх хэвлэх зардал	0	0		
13	Сурталчилгааны зардал	10216,0	9141,0		
14	Болзошгүй зардал	3000,0	0,0		
15	Дүн	488830,2	479052,2	177182,0	171428,4

Дээрх хүснэгтээс харахад сонгууль зохион байгуулахад гарсан зардлын нэр төрөл нь Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасан зардлын нэр төрөлтэй нийцэж байна. Нийт сонгуулийн зардлын 58,9%-ийг сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын мөнгөн урамшуулал, хоолны зардал эзэлж байна.

Ээлжит сонгуулийн зардлаас 9778,0 мянган төгрөгийг, хоёр дахь санал хураалтын сонгуулийн зардлаас 5753,6 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл үлдсэн байна.

Батлагдсан төсвийн үлдэгдлийг Сонгуулийн Ерөнхий Хорооны 100900022001 тоот дансанд 9778033,11 төгрөгийг, 100900022401 тоот дансанд 5753600 төгрөгийг нийт 15531633,11 төгрөгийг тус тус төвлөрүүлэн ажилласан байна. Энэ нь Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 04 тоот тогтоолоор батлагдсан “Журам”-ын 3.3 – дахь заалттай нийцэж байна.

Сонгуулийн тухай хуулийн 38.3, 38.4-т заасны дагуу улсын бүртгэлийн үйл ажиллагаа болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зардлуудыг тус байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосон байна.

ОӨУБЕГ-аас баталсан сонгуулийн зардлын төсөв, гүйцэтгэл мянган төгрөгөөр

Зардлын зүйл	төлөв	гүйц	зөрүү
Цалингийн зардал	51,060.0	51,060.0	-
НДШ	5,616.6	5,616.6	-
Бичиг хэргийн зардал	8,500.0	8,176.8	(323,0)
Сургалтын зардал	3,090.0	3,090.0	-
Томилолтын зардал	13,572.0	15,011.0	1,439
Унааны зардал	13,650.0	11,267.4	(2,383)
Шуудан,холбооны зардал	1,345.0	2,661.8	1,317
Урамшуулал	2,105.0	2,105.0	-
Шуурхай багийн зардал	550.0	500.0	(50)
Тоног төхөөрөмж татах	4,713.0	4,713.0	-
Нийт	104,202	104,202	-

ОӨУБЕГ-аас сонгуулийн зохион байгуулах зардалд батлагдаж ирсэн төсвийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна. Тухайлбал: Бичиг хэргийн зардал/323.2/, унааны зардал/2382.6/, шуурхай багийн зардал/50.0/ мянган төгрөгөөр тус тус хэмнэснийг, холбооны зардал болон томилолтын зардлын эх үүсвэрт гүйлгэн зарцуулсан боловч дээд шатны сонгуулийн байгууллагад

буюу ОӨУБЕГ-т хүсэлт тавьж шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь Сонгуулийн ерөнхий

хорооны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт, тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.2¹ -д заасан заалттай нийцэхгүй байна.

Цагдаагийн хамгаалалт, тээвэр шатахуун, хоолны зардалд зориулан ЦЕГ-аас 17.4 сая төгрөгийг аймгийн Цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүжүүлсэн байна.

Батлагдсан төсвийг харуулбал дараах байдалтай байна. /мянган төгрөг/

№	Зардлын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Сонгуулийн холбооны зардал	2496,0	2496,0
2	Сонгуулийн хоолны зардал	12510,0	12510,0
3	Тээвэр шатахууны зардал	2400,0	2400,0
4	Нийт	17406,0	17406,0

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн гүйцэтгэлийн баримт материалыг хянаж үзэхэд батлагдсан

төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Бүлэг 2: Сонгуулийн зардлын нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй байна.

2.1 Сонгуулийн зардлын нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй байна.

Аймгийн сонгуулийн хороо МУ-ын Ерөнхийлөгийн ээлжит сонгууль болон хоёр дахь санал хураалтыг зохион байгуулсан сумдын сонгуулийн хорооны баримт материал, зардлын гүйцэтгэлийн тайлангуудыг хүлээн авч, нэгтгэн нэгдсэн тайланг гаргасан байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооноос ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн ээлжит сонгуулийн зардлын нэгдсэн тайлан, хоёр дахь санал хураалтын зардлын нэгдсэн тайланг тус тусад нь тайлагнасан байна. /Хавсралт-01/

Сумдын ирүүлсэн санхүүгийн тайлан, анхан шатны баримт материалуудыг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг бүрэн хийгээгүй байна. Тухайлбал: Өр, авлагын журнал хөтлөөгүй, тооцоо нийлээгүй, жолоочийн тооцоо бодоогүй, байна.
2. Сумдын сонгуулийн зардлын анхан шатны баримт материалуудыг түүвэрлэн хяналт хийхэд цаашид ашиглах боломжтой нийт 5281,0 мянган төгрөгийн бараа материалуудыг сумдын ИТХ-ын байгууллагад хүлээлгэн өгч тооцоо нийлээгүй, акт үйлдээгүй зөрчил илэрч байна. **Аудитаар зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж байна. /Хавсралт-02/**

2.2 Аймгийн Сонгуулийн хороо сонгуулийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны үйл ажиллагаанд тасралтгүй хяналт тавьж ажиллах зорилгоор дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

¹ 3.2- сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

1. Аймгийн сонгуулийн хорооны гишүүдийн ажил үүргийн хуваарь, сонгуулийн хорооны гишүүдийн сонгуулийн хорооны байранд ажиллах цагийн хуваарь, жижүүрийн хуваарь, аймгийн сонгуулийн хорооны ажлын төлөвлөгөө гаргаж батлан хэрэгжүүлсэн.
2. Төсөв санхүүгийн хувьд санхүүжилт олгох бүртээ хөрөнгө зарцуулах талаар тайлбар, зөвлөмжүүдийг хүргүүлсэн.
3. Аймгийн сонгуулийн хорооны гишүүдэд сумын сонгуулийн хороог хариуцуулан удирдлага арга зүйгээр ханган ажилласны зэрэгцээ сумдын сонгуулийн хороо, санал авах байранд Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар 11 удаа бичгээр, сумдыг хариуцсан ажилтнууд утсаар холбогдож зөвлөн тусалж ажилласан байна.
4. Сонгуулийн тухай хуулийг тайлбарлан таниулах, санал авах байр бэлтгэх, санал авах, тоолох ажиллагаа хэрэгжүүлэх, гэрчилгээ олгох зэрэг сургалтуудыг зохион байгуулсан байна.
5. Сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.18-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үүднээс орон нутгийн “ЛХА”, “ХӨВСГӨЛ”, “МӨРӨН”, “ДАЛАЙ ЭЭЖ” 4 телевиз, “ЭРХ ЧӨЛӨӨ” сонин, Гэр бүлийн радио-104,5, Сорм FM-104 радио, “Хөвсгөлийн долгио” радиотой сонгуулийн хугацаанд хамтран ажиллах гэрээ байгуулж, сонгуулийн үйл ажиллагааг ард иргэдэд сурталчлан таниулж, холбогдох мэдээллийг цаг алдалгүй хүргэж ажилласан байна.
6. Аймгийн сонгуулийн хороонд иргэд, сонгогч, төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн нийт 3036 албан бичиг, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан байна.
7. Сонгуулийн хорооны мэдээллийг ил тод байлгах үүднээс аймгийн сонгуулийн хорооноос гарсан тогтоол, зөвлөмж шийдвэрүүдийг бүх сумдын сонгуулийн хороодод хүргүүлж, аймгийн сонгуулийн хорооны facebook – т тухай бүр нь тавьж ажилласан байна.

Нийцлийн аудитаар нийт 7,9 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрч үүнээс 5,2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн ажилласан болно.

ДҮГНЭЛТ

1. Сонгуулийн Ерөнхий Хорооноос Хөвсгөл аймагт МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардалд 488,8 сая төгрөг, хоёр дахь санал хураалтын зардалд 177,2 сая төгрөгийн санхүүжилтыг тус тус хуваарилан олгосон байна.
2. Төсвөөс олгосон хөрөнгийг аймгийн сонгуулийн хороо сумдын сонгуулийн хороодод зардлын зүйл тус бүрээр төсөвлөж, хуваарилсан байна.
3. Сумдын сонгуулийн хороодод зардлын зүйл тус бүрээр төсөвлөж, хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл нийт 15531,6 мянган төгрөгийг журмын дагуу Сонгуулийн Ерөнхий Хорооны дансанд төвлөрүүлсэн байна.
4. Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Журам”-ын 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу зардлын тайлан гаргаж ирүүлсэн ба аймгийн сонгуулийн хороо дээрх журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу нэгдсэн тайлан гаргасан байна.
5. Улсын бүртгэлийн хэлтэс батлагдсан төсвийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна.
6. Сонгуулийн зардлын нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй, цаашид ашиглах боломжтой бараа материалуудыг сумдын ИТХ-ын байгууллагад хүлээлгэн өгч тооцоо нийлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн сонгуулийн хорооны дарга Х.Ган-очир-т:

1. Сонгуулийн санхүүжилтээр бэлтгэгдсэн цаашид ашиглах боломжтой бараа материалуудыг шат шатны ИТХ-ын байгууллагад хүлээлгэн өгч, акт үйлдэх
2. Сумдын сонгуулийн хорооны санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийг иж бүрэн хөтлөх

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга М.Очирхуяг-т:

3. Хуваарилсан зардлыг шаардлагатай тохиолдолд эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахдаа дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлж байх.

ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

/ сая төгрөг/

№	Зөрчлийн утга	Аудитаар илэрсэн		Өгсөн албан шаардлага		Тавьсан акт		Зөвлөмж	
		Зөрчлийн агуулга	Зөрчлийн дүн /сая төгрөг/	тоо	Дүн /сая төгрөг/	тоо	Дүн /сая төгрөг/	тоо	Дүн /сая төгрөг/
1	Улсын бүртгэлийн хэлтэс батлагдсан төсвийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна.	төсвийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан	2,7					1	2,7
3	Зарим сумуудын сонгуулийн зардлын баримт материалуудыг түүвэрлэн шалгахад цаашид ашиглах боломжтой нийт 5,2 сая төгрөгийн бараа материалуудыг холбогдох байгууллагад хүлээлгэн өгч тооцоо нийлээгүй, акт үйлдээгүй байна.	нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, шаардахаар зардал болгосон	5,2	1	5,2				
4	Сумдын Сонгуулийн хороо:- Нягтлан бодох бүртгэл хөтөлтийг бүрэн хийж гүйцэтгээгүй. Тухайлбал: Өр, авлагын журнал хөтлөөгүй, тооцоо нийлээгүй, жолоочийн тооцоо бодоогүй, байна.	Өр авлагын тооцоо нийлсэн акт үйлдээгүй,анхан шатны баримтын бүрдүүлбэр дутуу						1	
	дүн		7,9	1	5,2			2	2,7

Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 3
дугуур сарын 02-ны өдрийн 04 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ЗАРДЛЫН НЭГДСЭН ТАЙЛАН

Тайлан гаргасан огноо : 2017.07.25

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сонгуулийн бичиг баримт болон техник хэрэгслийг сум дүүргийн сонгуулийн хороо санал авах байранд хүргэх буцаан татах тээвэрлэх зардал	23559000	21774320	1784680
2	Тогтоол протокол бусад маягт хэвлүүлэх зардал	250000	215620	34380
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал / Эрчим хүчний эх үүсвэр /	5124000	5124000	0
4	Дүн мэдээ дамжуулах зардал	7050000	3416400	3633600
5	Санал авах байр бэлтгэх тохижуулах зардал	23970000	23970000	0
6	Сургалтын зардал	24306000	24265500	40500
7	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллага ажилласан хугацааны мөнгөн урамшуулал хоолны зардал	282157200	282126800	30400
8	Бичиг хэргийн зардал	27560000	27560000	0
9	Шуудан холбооны зардал	24610000	24608526.89	1473.11
10	Унааны зардал	49805000	49630000	175000
11	Томилолтын зардал	6420000	6420000	0
12	Сурталчилгааны зардал	10216000	9141000	1075000
13	Болзрошгүй зардал	3000000		3000000
14	Бусад зардал / саналын хуудас устгах /	803000	800000	3000
15	Буцаан төвлөрүүлэх / үлдэгдэл буцаав /		9778033.11	-9778033.11
				0
				0
				0
	ДҮН	488830200	488830200.00	0

ТАЙЛАН ГАРГАСАН :

АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ДАРГА

НЯБО

Батчулуун

Х. ГАНОЧИР

Г. БАТЧУЛУУН

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН НЭГДСЭН ТАЙЛАН /хоёр дахь санал хураалт/

Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 3
дугуур сарын 02-ны өдрийн 04 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ 2 ДАХЬ САНАЛ ХУРААЛТЫН ЗАРДЛЫН
НЭГДСЭН ТАЙЛАН**

Тайлан гаргасан огноо : 2017.07.25

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сонгуулийн бичиг баримт болон техник хэрэгслийг сум дүүргийн сонгуулийн хороо санал авах байранд хүргэх буцаан татах тээвэрлэх зардал	20013000	14734400	5278600
2	Тогтоол протокол бусад маягт хэвлүүлэх зардал			0
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал / Эрчим хүчний эх үүсвэр /	5124000	5124000	0
4	Дүн мэдээ дамжуулах зардал	7050000	6725000	325000
5	Санал авах байр бэлтгэх тохижуулах зардал			0
6	Сургалтын зардал			0
7	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллага ажилласан хугацааны мөнгөн урамшуулал хоолны зардал	132680000	132680000	0
8	Бичиг хэргийн зардал	2390000	2390000	0
9	Шуудан холбооны зардал	3000000	3000000	0
10	Унааны зардал	6925000	6775000	150000
11	Томилолтын зардал			0
12	Сурталчилгааны зардал			0
13	Болзошгүй зардал			0
14	Бусад зардал			0
15	Буцаан төвлөрүүлэх / үлдэгдэл буцаав/		5753600	-5753600
				0
				0
				0
	ДҮН	177182000	177182000	0

ТАЙЛАН ГАРГАСАН
АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ДАРГА
НЯБО *Батцэцэг* Х. ГАНОЧИР
Г. БАТЧУЛУУН

Хавсралт №- 02

Худалдан авсан бараа материалын жагсаалт

№	Сумдын нэр	үзүүлэлт	тоо ширхэг	нэг бүрийн үнэ	бүгд үнэ
1	Тосон цэнгэл	тооны машин	5	16 000	80 000
		ханын цаг	5	16 000	80 000
		дрилл	1	45 000	45 000
		уртасгагч	2	16 500	33 000
		галын хор	5	40 000	200 000
		нийт	18	133500	438000
2	Их уул	залгуур	6	29 900	179 400
		дамартай залгуур	5	55 000	275 000
		тооны машин	5	16 000	80 000
		мэдээллийн самбар5	5	25 000	125 000
		хаалт	5	20 000	100 000
		нийт	26	145900	759400
3	Төмөрбулаг	плаш	1	11 000	11 000
		плаш	1	15 000	15 000
		плаш	1	20 000	20 000
		тооны машин	1	9 500	9 500
		уртасгагч	1	22 000	22 000
		нийт	5	77500	77500
4	Галт	уртасгуур	5	14 000	70 000
		галын хор	5	40 000	200 000
		нийт	10	54000	270000
5	Рэнчинлхүмбэ	тооны машин	3	5 000	15 000
6	Тариалан	гэрийн бүрээс	1	80 000	80 000
		гэрийн бүрээс	1	100 000	100 000
		цаваг	1	35 000	35 000
		мэдээллийн самбар	2	33 680	67 360
		мэдээллийн самбар	1	31 000	31 000
		Нийт	6	279680	313360
7	Бүрэнтогтох	тооны машин	1	20 000	20 000
		галын хор	1	50 000	50 000
		нийт	2	70000	70000
8	Алаг-Эрдэнэ	тооны машин	1	10 000	10 000
		уртасгагч	1	14 500	14 500
		нийт	2	24500	24500
9	Баянзүрх	мэдээллийн самбар	5	36 000	180 000

		тооны машин	1	18 000	18 000
		уртасгагч	4	15 000	60 000
		Нийт	10	69000	258000
10	Цагаан-үүр	Олон залгуур	2	15000	30000
		Цоож	1	5000	5000
		Кабель утас	14,8	2500	37000
		галын хор	1	30000	30000
		уртасгагч залгуур	1	25000	25000
		ширээний бүтээлэг	2	13000	26000
		жижиг хайрцаг	2	8000	16000
		галын хор	1	25000	25000
		галын хор	3	30000	90000
		Нийт	27,8	153500	284000
11	Мөрөн сүм	уртасгагч утас	80	1000	80000
		уртасгагч	2	15000	30000
		гар чийдэн	1	10000	10000
		үдээсний машин	1	4200	4200
		уртасгагч	1	25000	25000
		Цоож	1	15000	15000
		Гэрэл	10	10000	100000
		хасах гэрэл	4	15000	60000
		HD залгуур	4	10000	40000
		Дамартай уртасгагч	1	20000	20000
		хулдаас	3	5000	15000
		гэрэл	4	15400	61600
		уртасгагч	1	15000	15000
		хасах гэрэл	1	12000	12000
		кварц гэрэл	1	50000	50000
		томруулдаг шил	4	2500	10000
		Хулдаас	30	3000	90000
		Лед гэрэл	4	15000	60000
		өдрийн гэрэл	6	10000	60000
		уртасгагч	1	18000	18000
		Нийт	160	271100	775800
12	Шинэ-Идэр	Олон залгуур	2	20000	40000
		Олон залгуур	1	10000	10000
		Уртасгагч	2	15000	30000
		ширээний бүтээлэг	1	13500	13500
		Олон залгуур	1	20000	20000
		Олон залгуур	1	20000	20000
		Уртасгагч	2	15000	30000
		Плаш	5	16000	80000
		Дүн	15	129500	243500
13	Цагаан-уул	галын хор	1	50000	50000

		гар чийдэн	2	2500	5000
		Цүнх / хавтастай/	6	10000	60000
		Кабель утас	10	3500	35000
		уртасгагч залгуур	1	17500	17500
		Мэдээллийн самбар	1	35000	35000
		галын хор	2	60000	120000
		уртасгагч	4	20000	80000
		Мэдээллийн самбар	2	20000	40000
		Дүн	29	218500	442500
14	Цагаан-нуур	уртасгагч	3	27000	81000
		уртасгагч	1	18000	18000
		Цоож	2	5000	10000
		Дүн	6	50000	109000
15	Ханх	уртасгагч	3	25000	75000
		хувин	1	15000	15000
		Цоож	2	5000	10000
		Уртасгагч	2	20000	40000
		Дүн			140000
16	Цэцэрлэг	уртасгагч	7	14000	98000
		гэрлийн утас	100	2000	200000
		ширээний бүтээлэг	12	5500	66000
		Сектор	12	12500	150000
		ширээний хулдаас	9	6000	54000
		Дүн	140	40000	568000
17	Улаан-уул	Олон залгуур	5	8500	42500
		Цахилгаан утас	75	3000	225000
		Дүн			267500
18	Чандмань-Өндөр	Плаш	2	25000	50000
19	Эрдэнэбулган	Мэдээлийн самбар	5	35000	175000
20	Нийт дүн		462	1 746 680	5 281 060

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Тайлбар

хариу



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Нийцлийн аудитын Зөрчлийн жагсаалтанд дараах тайлбарыг хүргүүлж байна.

1. Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүжилтийн зарцуулалт тухайн байгууллагуудаараа дамжин хийгдсэн иймд аймгийн сонгуулийн хорооны үйл ажилгаатай хамааралгүй болно.

2. 5.2 сая бараа материалыг 2017 оны 09 дүгээр сарын 30-ны дотор холбогдох байгууллагуудад нь хүлээлгэн өгч акт үйлдэх болно. Сонгуулийн тухай хуульд сонгуулийн хорооны болон санал авах байрыг Засаг даргын тамгын газрууд бэлтгэж өгөхөөр тусгасан байдаг тул бараа материалыг холбогдох байгууллага буюу сумдын Засаг даргын тамгын газруудад хүлээлгэн өгөх саналтай байна.

3. Хүлээн зөвшөөрч байна.

№18
ДАРГА

Х.ГАН-ОЧИР

My Doc A-5

1. Улсын бүртгэлийн хэлтсийн удирдлагад танилцуулж хүлээн зөвшөөрүүлсэн болно.
2. Саналыг хүлээн авч "холбогдох байгууллага"-д гэж өөрчилсөн болно.